



22140603



**MONGOLIAN A: LITERATURE – STANDARD LEVEL – PAPER 1**  
**MONGOL A : LITTÉRATURE – NIVEAU MOYEN – ÉPREUVE 1**  
**MONGOL A: LITERATURA – NIVEL MEDIO – PRUEBA 1**

Friday 9 May 2014 (morning)

Vendredi 9 mai 2014 (matin)

Viernes 9 de mayo de 2014 (mañana)

1 hour 30 minutes / 1 heure 30 minutes / 1 hora 30 minutos

---

**INSTRUCTIONS TO CANDIDATES**

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a guided literary analysis on one passage only. In your answer you must address both of the guiding questions provided.
- The maximum mark for this examination paper is *[20 marks]*.

**INSTRUCTIONS DESTINÉES AUX CANDIDATS**

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez une analyse littéraire dirigée d'un seul des passages. Les deux questions d'orientation fournies doivent être traitées dans votre réponse.
- Le nombre maximum de points pour cette épreuve d'examen est *[20 points]*.

**INSTRUCCIONES PARA LOS ALUMNOS**

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un análisis literario guiado sobre un solo pasaje. Debe abordar las dos preguntas de orientación en su respuesta.
- La puntuación máxima para esta prueba de examen es *[20 puntos]*.

Доорх хоёр зохиолоос зөвхөн **нэгийг** нь сонгож, хөтөч хоёр асуултын дагуу уран зохиолын талаас задлан тайлбарлаж бич.

1.

-Аав, аав та үзэгтүн. Тэр нарны дэргэд бүхий таван өнгийн үүлний дотроос нэг их гэрийн чинээ том шувуу гарч ирэв. Хамаг биенээс нь улаан гэрэл цацарсан мэт бөгөөд явах чимээ нь яасан их вэ? Энэ ямар шувуу вэ? Түргэн үзээрэй, түргэн үзээрэй! гэхэд өвгөн их л гайхан “Хаана байна, хаана байна?” хэмээн тэр заасан  
5 зүгт ажиглан үзвээс үнэхээр нэгэн их гайхамшигтай шувуу мөний тул өвгөн яаран хэлрүүн: -Хүүхэд, хүүхэд! Та нар сайтар нарийвчлан үзэж байгаарай. Энэ магад бурхны элч тэнгэрийн шувуу гарьд галбингаа хэмээгч буй заа. Өвгөн би бурхан тэнгэрт биширсний ачаар энэ шувуу бидэнд харагдсан буй заа хэмээхэд хоёр хөвгүүн нь нүд чавчилгүй харж байв. Тэр их шувуу шууд зүүн зүгт нисэж явтал гэнэт  
10 тэр шувууны хойноос нэгэн олон юм бутран унахыг үзээд бага хөвгүүн хашгиран хэлрүүн: -Аав, аав! Шувуунаас нэг олон хоргол унаж ирэв гэхэд өвгөн яаран босож асууруун: -Сайн хараарай. Түүний хорголыг олбол туйлын их адис болой. Хүүхэд харж бай, харж бай! гэхэд хоёр хөвгүүн нь харан байтал тэдгээр унасан юм нь шууд нэгэн газар унахгүй, харин зүг бүр бутран явах нь болжмор шувуу мэт үзэгдэн байтал  
15 гэнэт нэг юм нь эднийг чиглэн салхины аясаар хийсэгдэн ирэхэд хоёр хөвгүүн их л баярлан дэвхцэж хэлрүүн: -Биднийг чиглэж нэг ирлээ. Биднийг чиглэж нэг ирлээ гэж байтал тэр юм нь шууд хийсэн ирээд өвгөний өвөр дээр унахад хоёр хөвгүүн хэлрүүн: -Аав, аав! Тэнгэрийн шувуунаас буусан нь хоргол бус ном байна, ном байна. Таны өвөр дээр буув гэхэд өвгөн “ном” хэмээхийг сонсоод цочин атал  
20 бас “өвөр дээр чинь буув” гэхэд их л сандран яарч тэрхүү номыг авч үзвэл нэгэн ам хэмжээний дөрвөлжин цаас бөгөөд дээр нь монгол үсгийг алтаар бичсэн ном мөний тул энэ магад тэнгэр бурхнаас ертөнцийн оронд ном тараав хэмээн яаран мэгдэн гурвуулан газарт сөгдөн мөргөж тэрхүү номыг сайтар эвхээд өвөрт агсан “Алтангэрэл”-ийн судрын баринтагтаа хамтатган агуулаад ямар ч эрдэнэ олсноос  
25 илүүгээр баярлан, өнөөх таягтай явдаг өвгөн бээр таягаа ч мартаад тэрхүү номыг хоёр гараараа дээр өргөн, гэртээ хүрч, мэддэг хүнээр үзүүлсүгэй хэмээн санах тутам хоёр хөл нь нисэх мэт түргэн болж явахад хоёр бага хөвгүүн хойноос нь гүйцэхгүйгээр гүйн одов.

Тэндээс өвгөн бээр хоёр хөвгүүнээ дагуулан гэртээ ирээд яаран мэгдэн эмгэнээ хүж зул асаа хэмээн асаалгаж, номоо дээр залаад түүний тэнгэрээс бууж  
30 ирсэн учрыг эмгэндээ хэлэн байтал гаднаас нэгэн хүн орж ирэв. Өвгөн үзээд яаран хэлрүүн: -Сайн уу, Дорж? Юутай сайн учрал болов. Би саяхан огторгуйгаас буусан ном олж авсан тул та надад уншиж өгнө үү? гэхэд Дорж хэлрүүн: -Юу гэнэ ээ, огторгуйгаас ямар ном яахан буув? гэхэд өвгөн буусан учрыг хэлээд номоо авч  
35 өгөхөд Дорж тэрхүү номыг авч их дуугаар уншсан нь: Энэхүү аргын долоон сарын арван нэгний өдөр\* бол манай монголчуудын ардын эрхт Бүгд Найрамдах Улсын тулгуурыг байгуулсан их баярын өдөр бөгөөд энэ өдрийн утга чанар нь монголын дарлагдсан ба бэлчээрт зүдэрсэн жинхэнэ ард түмэн эрх чөлөөгөө олж, эрдэм соёлын гэгээн замд давшихын үүд нээгдэж, эртнээс нааш хэдэн зуун жил харанхуй  
40 мананд төөрснөөс тонилон гэтлэхийн мөрийг олсон нь болох тул бидний ард олноор хэзээ ямагт умарталгүй сэтгэл зүрхэндээ тэмдэглэхээс гадна жил бүр өөр өөрийн

45 баяр дурсгал мэт осолдолгүй ёслон өнгөрөө, жил жилээс дээш дэвшиж бүхийгээ тэмдэглэвэл зохино гэх зэрэг уншжээ. Тэд нар үүнийг сонсоод сая ардын намын нисдэг тэрэг олон түмэнд бичиг тараасан ба ард түмний эрх чөлөөг дэлгэрүүлсэн нь энэ өдөр ажгуу хэмээн мэдэж, түүнээс хойш жил бүр энэ өдөр болмогц бичиг тараах дурсгал ёслолд жагсах хэмээн тасралтгүй явах болжээ.

С.Буяннэмэх, *Гайхамшигт байдал* (1996)

---

\* 1921 онд Ардын хувьсгал ялсан бөгөөд уг өдрийг их баярын өдөр хэмээн тэмдэглэх болсон билээ.

- (а) Доржийн дүрийн ач холбогдлыг тайлбарлан бич.
- (б) Зохиолчийн бүтээлдээ ашигласан адилтгал зүйрлэл, хэтрүүлэл гэх мэт уран дүрслэлийн аргын ач холбогдлыг задлан тайлбарла.

2.

Найман шарга морийг нэхэхэд  
Наран гарах цагт учирч  
Насан турш хүчээ өгсөн  
Наху баяны хөвгүүн  
5 Сайн хөлөг Боорчи минь!  
Айл зуур явахад  
Алаг бяруу мэт аашит  
Алалдах дайсантай учрахад  
Амь биеэ үл хайрлагч  
10 Хөлөг Боорчи минь!  
Ханилан явах цагт  
Хашин хар бяруу мэт  
Харьтан дайсантай учрахад  
Харцага шувуу мэт довтлон орогч  
15 Хөлөг Боорчи минь!  
Инээлдэн явах цагт  
Ижил хар бяруу мэт аашит  
Идэмхий дайсан учрахад  
Эрэмгий шувуу мэт довтлон орогч  
20 Хөлөг Боорчи минь!  
Наадан инээлдэн явах цагт  
Нялх унага мэт аашит  
Наад цаад лугаа хатгалдахад  
Начин шонхор мэт довтлон орогч  
25 Хөлөг Боорчи минь!  
Хатуу дайсан учрахад  
Харил буцалгүй явж  
Хаан эзнийхээ биеэс  
Харин хол үл эчигч  
30 Арга сайт хөлөг Боорчи минь!

Зохиогч нь тодорхойгүй, *Гурван зуун тайчуудыг дарсан домог* (1990)

- (а) Энэхүү шүлэгт илэрхийлсэн санаануудыг (үнэнч байх гэх мэт) хэрхэн ойлгосноо тайлбарла?
- (б) Шүлэгт толгой болон сүүл холболтыг хэрхэн ашигласан байна вэ?